

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ШИНЭЧЛЭЛ

Better talk, talk, talk than war, war, war

Winston Churchill

*Д.Оюунсүрэн**

Хорьдугаар зуунд дэлхийн хоёр ч дайны гамшигт нэрвэгдэж, асар их гарз хохирол, уй гашууг амссан улс үндэстнүүд хойч үеийнхнийгээ дахин тийм аюулд автуулахгүй байхын тулд дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах НҮБ-ыг бий болгосноос хойш даруй жаран жил өнгөрчээ. Гэвч энэ хугацаанд хүн төрөлхтөн 180 гаруй том жижиг дайн байлдаанд 20 сая гаруй ах дүүсээ алдаж, тэдгээр хямралын олонхийнх нь өмнө НҮБ хүчин мөхөсдөж байсан билээ. Зөвхөн ганц энэ жишээ л гэхэд энэхүү байгууллага анх үүсгэн байгуулагдахдаа өмнөө тавьж байсан зорилтоо хангалттай биелүүлж байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэдэг.

НҮБ-ын шинээр сонгогдсон Ерөнхий нарийн бичгийн дарга бүр өргөн хүрээтэй шинэчлэл хийхээр амладаг хэдий ч амьдрал дээр тэр нь ихэвчлэн зохион байгуулалтын чанартай л асуудлыг хөнддөг. Сүүлийн жилүүдэд НҮБ-ын шинэчлэлийн асуудлыг урьд урьдынхаас илүү эрчтэйгээр сөхөн тавих болсон билээ.

Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэл

Төгс төгөлдөр зүйл гэж хорвоод байдаггүй. Бүх л зүйл хувьсан өөрчлөгдөж байдаг бол харин НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн энэ бүтэц 1945 оны дэлхийн улсуудын хүчний хуваарилалтыг тусгасан тэр л хэлбэрээрээ ХХI зууныг угтсан нь олон хүний гайхлыг төрүүлдэг.

1989 онд Италийн гадаад хэргийн сайд Франц, Их Британийг Аюулгүйн зөвлөлөөс өөрчилж, оронд нь Япон, Европын Хамтын Нийгэмлэгийг оруулах санал албан бусаар гаргаж байв. Уг саналыг P5-2+2 хэмээн томъёолдог. Харин

* МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

энэхүү хаалттай сэдэв албан ёсоор 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47-р чуулганы үеэр Япон, Герман улсууд Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болох саналаа илэрхийлснээр анх хөндөгдсөн билээ.

Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн талаар сүүлийн үед түгээмэл гарч буй саналуудыг ангилан үзье.

1. Аюулгүйн Зөвлөлийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх

Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн тоог нэмэгдүүлэх асуудал байнга яригдсаар ирсэн ба Энэтхэг, Япон, Герман, Бразил зэрэг улсуудыг хамгийн бололцоотой нэр дэвшигч гэж үздэг. Гэхдээ энэ санааг хэрэгжүүлэхэд нэлээд бэрхшээлтэй тулгарна. Их Британи, Франц, ОХУ зэрэг улс Герман, Бразил, Энэтхэг, Японыг зарчмын хувьд дэмжиж байгаа боловч БНХАУ Японыг огтоос дэмжих бодолгүй байгаа юм. Энэ нь ялангуяа Япон улс дэлхийн II дайны үед үйлдсэн харгислалынхаа төлөө албан ёсоор уучлал гуйхаас татгалзсаар ирсэнтэй холбоотой. Хятад төдийгүй Хойд ба Өмнөд Солонгос Японыг цэрэг улс төрийн хүч чадлаа нэмэгдүүлэхээс нь мөн болгоомжилдог.

Францын Ерөнхийлөгч Жак Ширак “Аюулгүйн Зөвлөлийн одоогийн бүтэц нь дэлхий ертөнцийн бодит байдлыг тусгаж чадахгүй байгаа тул Герман, Япон улсуудыг түүний бүрэн эрхтэй, байнгын гишүүн болгох асуудлыг дэмжих хэрэгтэй байна. Мөн хөгжиж буй орнуудын төлөөллийг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байна” хэмээн 1995 онд мэдэгдэж байв.¹

Цаашлаад Пакистан Энэтхэгийн, Мексик, Аргентин хоёр Бразилийн нэрийг дэвшүүлэхээс татгалзаж байгаа юм. Гэтэл Итали улс Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн тоог нэмэгдүүлэх ийм шинэчлэлийг огтоос дэмжихгүй байгаа ба зарим нэг улстай хамтран хагас байнгын гишүүний орон тоо бий болгох талаар санал оруулсан.

Ерөнхийлөгч Ж.Бушийн засаг захиргаа 2003 онд Иракийг довтлоход эсэргүүцсэн байр суурь баримталж байсан Герман улсыг байнгын гишүүн болгох асуудлыг дэмжихээ орхиж, харин Японыг дэмжиж байгаа юм. Төрийн нарийн бичгийн дарга Кондолеза Райс Токиагийн Софиа их сургуульд хэлсэн үгэндээ

¹ Jacques Chirac, Discours-programme de politique étrangère, le 16 mars 1995

”Япон улс дэлхийн улс түмнүүдийн дунд өөрийн зүтгэл, онцлог чанараараа хүндтэй байр суурь эзэлсэн. Тийм ч учраас АНУ Японыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болох асуудлыг огтхон ч эргэлзэлгүй дэмжиж байгаа юм” хэмээн онцлон тэмдэглэсэн. Харин өмнөх Төрийн нарийн бичгийн дарга Колин Пауэл Японы үндсэн хуулийн 9-р зүйлд тус улс дайнд оролцохыг хориглосон заалт байдгийг үндэслэн байнгын гишүүнд нэр дэвших асуудлыг нь эсэргүүцэж байсан билээ.

Түүнээс гадна Африкийн улсуудад нэг байнгын гишүүний суудал олгох ёстой гэсэн зүй ёсны санал гарсаар ирсэн бөгөөд хамгийн боломжтой нэр дэвшигч бол ӨАБНУ юм.

Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн тоог нэмэгдүүлэх талаар Францын гадаад хэргийн сайд асан Алайн Жуппе “15 гишүүнтэй ажиллаж болно. 30 гишүүнтэй болчихвол замбараагүйдэл үүснэ. Ажлын үр дүн, олон талын төлөөлөл хоёрын дундах тэнцвэртэй цэгийг олох л хамгийн чухал юм” хэмээснийг дурдах нь зүйтэй болов уу .

2. Европын Холбоог Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болгох

Европын интеграци улам гүнзгийрэхийн хэрээр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл дэх Их Британи, Францын суудлыг устгаж, Европын Холбоонд олгох санал улам хүчтэй яригдах болсон. Гэхдээ Европын Холбоо нь бие даасан улс биш учраас энэ саналыг хэрэгжүүлэхийн тулд нэг бол НҮБ-ийн дүрэмд өөрчлөлт оруулах, эсвэл Европын Холбоо нэг улс болох шаардлагатай.

3. Байнгын гишүүдийн вето тавих эрхийг цуцлах

Аюулгүйн Зөвлөл зарчмын чухал асуудлаар (аль нэг улсыг буруушаах, гал зогсоох буюу цэргээ гаргахыг шаардах, хориг арга хэмжээ авах, энхийг сахиулах хүчинд мандат олгох, маргааныг шийдвэрлэх, гишүүнээр элсүүлэх буюу гишүүнээс хөөх, Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох г.м.) шийдвэр гаргахад байнгын 5 гишүүнийг оролцуулан 9 санал хэрэгтэй байдаг бөгөөд ганцхан байнгын гишүүний эсрэг санал бусад 14 гишүүний саналыг хүчингүй болгодог. Үүнийг хориг буюу вето тавих эрх хэмээн нэрлэдэг бөгөөд энэ ардчилсан бус

тогтолцоог халахыг олон улс орон хүсдэг хэдий ч одоогийн байнгын гишүүдээс хэн нь ч энэхүү давуу эрхээсээ сайн дураараа татгалзахыг хүсэхгүй байгаа юм.

Үнэндээ вето тавих эрх бол НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн үйл ажиллагааг саармагжуулж байдаг гол шалтгаан бөгөөд 1946-1995 оны хооронд Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүд 237 удаа энэхүү эрхээ хэрэглэсэн байдаг. Роман Гари өөрийн бүтээлд вето тавих эрхийг эрс шүүмжилж “Аюулгүйн Зөвлөл ямар ч цогцос, ямар ч хүйс тэмтрэлт, ямар ч боолчлолыг аль нэг их гүрний тавьсан ветоогоор булшилж чадна” хэмээсэн байдаг.²

In Larger Freedom буюу ЕНБД-ын санал

2005 оны 3-р сарын 21-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан Аюулгүйн Зөвлөлийг 24 гишүүнтэй болгож өргөжүүлэх талаар зөвшилцөлд хүрэхийг уриалсан “In Larger Freedom” хэмээх төлөвлөгөөг танилцуулсан юм. Тэрээр 2 хувилбарыг танилцуулсан боловч алийг нь илүү дээр гэж үзэж байгаагаа илэрхийлээгүй. Гэвч тэрээр энэ асуудлыг аль болох хурдан шийдвэрлэхийг хүсэж байна гэсэн. Энэхүү 2 хувилбар нь:

- “А” хувилбар: Шинээр 6 байнгын гишүүн, 3 байнгын бус гишүүнийг бий болгож Аюулгүйн зөвлөлийн нийт гишүүдийн тоог 24-т хүргэх;
- “Б” хувилбар: 8 шинэ статустай гишүүдийг бий болгож 4 жил тутам шинэчилж байх, дээрээс нь 1 байнгын бус гишүүний суудлыг нэмээд нийт 24 гишүүнтэй болгох.

Санхүүгийн шинэчлэл

НҮБ-ын өөр нэг тулгамдсан асуудал бол санхүүгийн шинэчлэл юм. Уг байгууллага жилд 10 тэрбум ам.доллар зарцуулдаг нь дэлхийн нэг хүн амд 1,70 доллар оногддог гэсэн хэрэг юм. Энэ нь ихэнх засгийн газрын төсөвтэй харьцуулахад маш бага хэмжээ бөгөөд дэлхийн цэрэг дайны зардлын өчүүхэн хэсэгтэй дүйнэ. Гэсэн хэдий боловч НҮБ сүүлийн хорин жилд санхүүгийн асар их хямралд өртөж, маш олон чухал хөтөлбөрийхөө төсвийг танаж тайрахаас аргагүй байдалд ороод байгаа юм. Гол шалтгаан нь олон улс орон гишүүний татвараа цаг

² Romain Gary, *La nuit sera calme*, Paris, 1974

тухайд нь төлдөггүй, сайн дурын санд өгөх хандиваа багасгасантай холбоотой. 2005 оны 9-р сарын 30-ны байдлаар гишүүн орнууд НҮБ-ын ердийн төсөвт 743 сая ам.долларын өртэй байгаа ба зөвхөн АНУ дангаараа 607 сая ам.доллар буюу уг төсвийн 82 хувьтай тэнцэх хэмжээний өртэй байна³.

Олон судлаач НҮБ-ын санхүүжилтийг шинэчлэхийн тулд санхүүгийн өөр эх үүсвэр олох ёстой гэсэн саналтай байдаг. Тухайлбал:

- валют мөнгөний үйл ажиллагаанаас нэгдсэн татвар авах;
- байгаль орчны татвар авах;
- зэвсэглэлийн худалдаанаас татвар авах.

Харамсалтай нь НҮБ-ын төсвийн дийлэнх хувийг бүрдүүлдэг АНУ гэх мэт их гүрнүүд улс төрийн байр сууриа алдахаас эмээж санхүүгийн шинэчлэлийн асуудалд хойрго хандаж байгаа юм.

Санхүүжилтийн асуудлаар Поль Хокен "The Ecology of Commerce" номондоо сонирхолтой санал дэвшүүлжээ. Тэрээр дэлхий даяар зэвсгийн үйлдвэрлэлд олон улсын тариф тогтоохыг санал болгосон бөгөөд түүний тооцоолсноор "пуужин, нисэх онгоц, танк, бууны үйлдвэрлэлээс татвар авснаар НҮБ-ын бүх төсвийг бүрдүүлээд зогсохгүй, энхийг сахиулах үйл ажиллагааг ч санхүүжүүлэхэд хангалттай мөнгө хуримтална" гэж үзсэн.

³ www.globalpolicy.org